



# IPTV 2.0

---

## ГАРЫН АВЛАГА





## ГАРЧИГ

<b>1. IPTV 2.0 ТУХАЙ</b> .....	5
1.1. Универсалудирдлага.....	6
1.2. IPTV-г Асаах/Унтраах.....	7
1.3. IPTV-д Нэвтрэх/Гарах.....	7
<b>2. ТВ СУВГУУД</b> .....	9
2.1. Сувгийг ангилж үзэх.....	9
2.1. Санал болгосон нэвтрүүлэг харах.....	10
2.2. ТВ хөтөлбөр үзэх.....	10
2.3. Суваг сонгох.....	11
2.4. Суваг үзэх.....	12
2.5. Төлбөртэй суваг үзэх/түгжих.....	13
2.6. Нэвтрүүлэг дахин эхлүүлэх, түр зогсоох, нөхөж үзэх, гүйлгэх.....	13
2.8. Нэвтрүүлэг сануулах.....	14
<b>3. ВИДЕО САН (VOD)</b> .....	15
3.1. Видео санг харах.....	15
3.2. Видео контент түрээслэх.....	15
3.3. Видео контентийг түр зогсоох, зогсоох, гүйлгэх.....	15
3.4. Тэмдэглэгээ хийх.....	15
3.5. Видео контентийг бэлэглэх, санал болгох.....	16
3.6. Трейлэр үзэх, үзэх дуртай кино болгох.....	18
<b>4. МИНИЙ КОНТЕНТ</b> .....	18
4.1. Бичлэг хийх, үзэх, төлөвлөх.....	18
4.2. Flickr гэрэл зургууд.....	18
4.3. Санал болгосон видео контент.....	18
<b>5. ТВ АППЛИКЕЙШН</b> .....	20
5.1. Бүх аппликейшнийн жагсаалт харах.....	20
5.2. Миний аппликейшнийн жагсаалт харах.....	20
5.3. UnivisionStore жагсаалт харах.....	20
5.4. Үнэгүй аппликейшнийн жагсаалт харах.....	20
5.5. Өргөн хэрэглэгддэг аппликейшнүүдийг ашиглах.....	21

<b>6. ТОХИРГОО</b> .....	22
6.1. Үндсэн тохиргоо хийх.....	22
6.2. ТВ тохиргоо хийх.....	23
6.3. Хувийн тохиргоо хийх.....	23
6.4. Админ хяналт хийх.....	24
6.5. Төхөөрөмжийн тохиргоо хийх.....	24
6.6. Системийн тохиргоо хийх.....	25
6.7. Бусад тохиргоо хийх.....	25
<b>7. ПРОМО</b> .....	26
<b>8. ТӨЛБӨР</b> .....	27
8.1. Төлбөрийн дүнг харах.....	27
8.2. Видео сангийн төлбөр харах.....	27
8.3. Суурь хураамжийн төлбөр харах.....	28
<b>9. ТУСЛАМЖ</b> .....	29
<b>10. НАЙЗУУД</b> .....	30
10.1. Хувийн мэдээлэл харах.....	30
10.2. Найзуудын мэдээлэл харах.....	30
10.3. Найзын хүсэлт харах.....	30
10.4. Найзын хүсэлт илгээх.....	30
10.5. Найзууд хоорондоо чатлах, видео контент бэлэглэх, санал болгох.....	31
<b>11. ХАЙЛТ</b> .....	32
<b>12. “UNIVISION MONGOLIA” АППЛИКЕЙШН</b> .....	33
12.1. ТВ сувгууд үзэх.....	33
12.2. Видео контент үзэх.....	34
12.3. Тохиргоо хийх.....	34

## 1. IPTV 2.0 ТУХАЙ

---

### 1. IPTV 2.0 ТУХАЙ

IPTV2.0 үйлчилгээ нь телевиз үзэх эрх чөлөөг бүрэн мэдрүүлэх, техникийн дэвшилтэт үйлчилгээ юм. Та дэлхийн болон монголын шилдэг сувгуудыг дуу дүрсний өндөр чанар, монгол дуу оруулга, хадмал орчуулгатайгаар оюуны өмчийн эрхтэйгээр үзнэ. Мөн хүссэн видео контентоо ухрааж, зогсоож, гүйлгэж, нөхөж үзэх, найздаа бэлэглэх, санал болгох, бусад IPTV хэрэглэгчидтэй найзууд болох, хоорондоо чатлах, интернэт орчинд аппликейшн ашиглах боломжтой.


ТВ-ээрээ зөвхөн кино, нэвтрүүлгээ үзээд зогсохгүй интернэтийн мэдээ уншиж, Facebook, Twitter, Flickr зэрэг орчин үеийн сошиал мэдээллийн хэрэгслийг ашиглаж болно.

#### 1.1. УНИВЕРСАЛ УДИРДЛАГА

Универсал удирдлага нь хоёр удирдлага ашиглах шаардлагагүйгээр ТВ-ийн болон үйлчилгээний бүх цэсийг удирдах боломжтой. Цөөн үйлдлээр бүх зааврыг гүйцэтгэдэг Универсал удирдлагыг ашиглах зааврыг хүргэж байна.

- |   |                                |
|---|--------------------------------|
| 1. ТВ Асаах / Унтраах товчлуур                | 18. INFO товчлуур              |
| 2. Асаах / Унтраах товчлуур                   | 19. Улаан товчлуур             |
| 3. 0-9 хүртэлх товчуур                        | 20. Ногоон товчлуур            |
| 4. EXIT товчлуур                              | 21. Шар товчлуур               |
| 5. Өмнө үзэж байсан суваг руу шилжих товчлуур | 22. Цэнхэр товчлуур            |
| 6. VOD товчлуур                               | 23. Хойш ухраах товчлуур       |
| 7. Үндсэн цэс гаргах товчлуур                 | 24. Тоглуулах товчлуур         |
| 8. EPG товчлуур                               | 25. Урагш гүйлгэх товчлуур     |
| 9. Дуу Нэмэх / Хасах товчлуур                 | 26. Зогсоох товчлуур           |
| 10. OK товчлуур                               | 27. Түр зогсоох товчлуур       |
| 11. Дээш шилжих товчлуур                      | 28. Бичлэг хийх товчлуур       |
| 12. Доош шилжих товчлуур                      | 29. Туслах товчлуур            |
| 13. Зүүн тийш шилжих товчлуур                 | 30. ТВ хөтөлбөр харах товчлуур |
| 14. Баруун шилжих товчлуур                    | 31. L/R товчлуур               |
| 15. Суваг солих товчлуур                      | 32. Input selection товчлуур   |
| 16. Дуугүй болгох товчлуур                    | 33. E-mail товчлуур            |
| 17. Буцах товчлуур                            | 34. "Од" товчлуур              |

# 1. IPTV 2.0 ТУХАЙ



## 1. IPTV 2.0 ТУХАЙ

### 1.2. IPTV-Г АСААХ/УНТРААХ

Универсал удирдлага дээрээс (2) товчлуурыг дарж IPTV-г асаана. Нүүр хуудас зураг гарч ирэх хүртэл түр хүлээх ба энэ хооронд ямар нэг өөр товчлуур дарахгүй, төхөөрөмжөөр оролдохгүй байхыг анхаарна уу. IPTV-г унтраах бол Универсал удирдлага дээрээс (2) товчлуурыг дарж унтраана.

### 1.3. IPTV-Д НЭВТРЭХ/ГАРАХ

IPTV-г асаасны дараа дэлгэцийн баруун дээд буланд IPTV-г ашиглах эрхтэй гэр бүлийн гишүүдийн нэрсийн жагсаалт гарч ирэх ба хэрвээ таны нэр байхгүй бол гэр бүлийнхээ Админ эрхтэй хэрэглэгчээр шинэ бүртгэл үүсгэнэ. Хэрэглэгч бүрт IPTV-д нэвтрэх нууц үг байх ба өөрийн нэвтрэх нэрийг сонгоод нэвтрэх нууц үгийг бичиж (10) товчлуур дарснаар IPTV-д нэвтрэнэ. Хэрвээ нэвтрэх нууц үгээ буруу бичсэн бол (13) товчлуур дарж арилгана.

UNITEL

ShopOn апплейкшны хэрэглэгч та  
Юнителийн VIP салбараас  
Samsung Galaxy S4  
Samsung Galaxy S3  
гар утсыг худалдан авбал  
Galaxy Fame гар утсыг бэлгэнд авах болно.

UNIVISION  
Хэрэглэгчээ сонгоно уу

Delgermaa2PAS8

ANKHBAYAR

BATTULGA

Урамшуулал 2014.08.07 хүртэл

УХААЛАГ УТАС + УХААЛАГ УТАС ҮНЭГҮЙ

IPTV-ийн хэрэглэгчид 3 төрлийн нууц үгтэй байна. Үүнд:

1. **Нэвтрэх нууц үг:** Энэ нууц үг нь IPTV-д нэвтрэхэд, видео контент түрээслэхэд ашиглагдах юм. IPTV-ийн хэрэглэгч бүр өөрийн гэсэн нэвтрэх нууц үгтэй байх ба нууц үгээ солих бол Тохиргоо-Үндсэн тохиргоо-Нууц үг солих цэс рүү орж солино.

## 1. IPTV 2.0 ТУХАЙ

2. **Админ нууц үг:** Энэ нууц үг нь IPTV-ийн Админ эрхтэй хэрэглэгч нэвтрэх, Админы тохиргоо хийхэд ашиглагдах нууц үг. Дээрх нууц үгийг зөвхөн Админ эрхтэй хэрэглэгч авах ба нууц үгээ солих бол Тохиргоо-Админ хяналт-Админ нууц үг өөрчлөх цэс рүү орж солино.
3. **Univision Mongolia аппликейшнд нэвтрэх нууц үг:** Энэ нууц үг нь "My Univision" аппликейшнд нэвтрэхэд ашиглагдах 10 оронтой нууц үг юм. Хэрвээ дээрх нууц үгээ мартсан бол IPTV-ийн Тохиргоо-Бусад тохиргоо цэснээс харах боломжтой.

IPTV-ийн хэрэглэгчид 2 төрлийн нэртэй байна. Үүнд:

1. **Нэвтрэх нэр:** IPTV-н хэрэглэгч тус бүр нэвтрэх нэртэй байна. Дээрх нэрийг чөлөөтэй өөрчилж, товчилж болно. Хэрвээ нэвтрэх нэрийг солих бол Тохиргоо-Хэрэглэгчийн тохиргоо-Хувийн мэдээлэл цэснээс Нэвтрэх нэрийг сонгож солино.
2. **Чатын нэр:** Энэ нэр нь IPTV-ээр холбогдсон найзуудтайгаа чатлахад, видео контент санал болгох, бэлэглэхэд ашиглагдах нэр юм. Дээрх нэрийг өөрчлөхөд таны нэвтрэх нэр өөрчлөгдөхгүй. Хэрвээ чатын нэрийг солих бол Тохиргоо-Хэрэглэгчийн тохиргоо-Хувийн мэдээлэл цэснээс Чатын нэрийг сонгож солино.

(2) товч дарахад тухайн хэрэглэгчийн бүртгэл автоматаар гарч төхөөрөмж унтарна. Хэрвээ төхөөрөмжөө унтраахгүйгээр IPTV-ийн хэрэглэгчийг солих бол Тохиргоо-Үндсэн тохиргоо цэсний Хэрэглэгчийг солих сонголтыг сонгосноор нүүр хуудас руу шилжиж хэрэглэгчийн бүртгэлээс гарна.



## 2. ТВ СУВГУУД

### 2. ТВ СУВГУУД

#### 2.1. СУВГИЙН ТӨРЛӨӨР ҮЗЭХ


Сувгийн төрөл цэс рүү орсноор та IPTV-д гарч байгаа бүх төрлийн сувгуудыг төрлөөр нь ялгаж үзэх боломжтой. Сувгийн төрлийг гаргах үндсэн хоёр арга бий.

1. **ТВ сувгууд цэснээс:** ТВ сувгууд-Сувгийн төрөл цэсийг сонгох.
2. **Универсал удирдлага дээрээс:** Нэвтрүүлэг үзэж байхдаа (14) товчлуурыг дарж дэлгэцийн зүүн талд **Сувгийн төрөл** цэсийг гаргах.

**Сувгийн төрөл** цэсэнд дараах төрлүүд багтана. Үүнд:

- |                        |                   |              |
|------------------------|-------------------|--------------|
| 1. Бүх суваг           | 6. Орос сувгууд   | 11. Спортын  |
| 2. Үзэх дуртай сувгууд | 7. Таних мэдэхүйн | 12. Хүүхдийн |
| 3. Их үзсэн сувгууд    | 8. Энтертаймент   | 13. Киноны   |
| 4. Төлбөртэй сувгууд   | 9. Мэдээний       | 14. Радио    |
| 5. Монгол сувгууд      | 10. Хөгжмийн      |              |

Универсал удирдлага дээрээс (11,12) товчлууруудын тусламжтай сувгийн төрөл дээр очиж (14) товч дарахад сонгосон төрөлд багтах сувгийн жагсаалт гарч ирэх ба сувгууд дээр (11,12) товчлууруудын тусламжтай очиход суваг бүрийн ойрын хоёр цагийн хөтөлбөр гарч ирнэ. Харин сувгийн төрлөө сонгоод (10) товчлуур дарахад өмнө үзэж байсан суваг нь сонгосон ангилалын сувагаар солигдоно.



## 2. ТВ СУВГУУД

Үзэх дуртай сувгууд ангилалд багтах сувгийн сонголтыг Тохиргоо-ТВ тохиргоо-Үзэх дуртай сувгууд цэсэнд тохируулна.

### 2.1. САНАЛ БОЛГОСОН НЭВТРҮҮЛЭГ ХАРАХ

Танд санал болгосон нэвтрүүлгүүдийг уг цэснээс харах боломжтой. Хүссэн нэвтрүүлэг дээрээ (11,12) товчлуур ашиглан очиж (10) товчлуурыг дарахад тухайн нэвтрүүлгийн дэлгэрэнгүй мэдээлэл гарч ирнэ.

### 2.2. ТВ ХӨТӨЛБӨР ҮЗЭХ

Энэхүү цэсийг ашиглан ТВ хөтөлбөрүүдийг өдөр, цаг, сувгаар нь шүүн хайлт хийж үзэх, нөхөж үзэх, нэвтрүүлэг сануулах, бичиж хадгалах боломжтой. Хөтөлбөрөөс сувгийн төрлөөр болон огноогоор нь шүүн харах боломжтой. ТВ хөтөлбөрийг үндсэн хоёр аргаар гаргаж болно.

1. **ТВ сувгууд цэснээс:** ТВ суваг цэсний ТВ хөтөлбөр сонголтыг сонгох.
2. **Универсал удирдлага дээрээс:** (8) эсвэл (30) товчлуур дарах.

Суваг тус бүрийн хөтөлбөрийг үзэх бол тухайн сувгаа үзэж байхдаа Универсал удирдлага дээрээс (13) товчлуур дарахад дэлгэцийн баруун талд тухайн сувгийн хөтөлбөр гарч ирнэ. (11, 12) товчлуур ашиглан хөтөлбөрийг дээш доош гүйлгэн харах боломжтой.



## 2. ТВ СУВГУУД

Универсал удирдлага дээрээс (20) товчлуурыг дарж сувгийн төрлөөр нь шүүх ба (13, 14) товчлуурыг ашиглан дэлгэцийн зүүн дээд буланд байрлах сувгийн төрөл сонгох хэсгийг удирдана. Сувгийн төрлөө сонгоод (10) товчлуур дарахад хөтөлбөр сувгийн төрлөөрөө шинэчлэгдэнэ.

Харин Универсал удирдлага дээрээс (21) товчлуур дарж огноогоор шүүх ба (13, 14) товчлуурыг ашиглан дэлгэцийн дээд талд байрлах огноо сонгох хэсгийг удирдана. Шүүх огноогоо сонгоод (10) товчлуур дарахад хөтөлбөр огноогоор шинэчлэгдэнэ. ТВ хөтөлбөрөөс гарах бол Универсал удирдлага дээрээс (17) товчлуурыг дарна.

Универсал удирдлага дээрээс (11,12) товчлуурыг ашиглан үзэхийг хүссэн суваг дээрээ, нэвтрүүлэг сонгохдоо Универсал удирдлага дээрээс (13, 14) товчлуурууд ашиглан очиж (10) товчлуурыг дарахад суваг солигдоно.

### 2.3. СУВАГ СОНГОХ

Сувгийг хэд хэдэн янзаар сонгож болно. Үүнд:


1. Универсал удирдлага дээрээс (3) товчлуур ашиглах
2. Универсал удирдлага дээрээс (11, 12) товчлуур ашиглах
3. Универсал удирдлага дээрээс (15) товчлуур ашиглах
4. ТВ хөтөлбөрөөс сонгох
5. Сувгийн төрлөөс сонгох

Мөн үзэж байгаа сувгаа солихгүйгээр бусад суваг дээр ямар нэвтрүүлэг гарч байгааг үзэх боломжтой. Үүний тулд Универсал удирдлага дээрээс (10) товчлуурыг хоёр удаа дарахад дэлгэцийн зүүн доод буланд байрлах (сувгийн таних тэмдэг, сувгийн нэр, сувгийн төрөл) мэдээллүүдийн дэвсгэр өнгө нь саарал болсон байна. (Зураг)



Энэ үед Универсал удирдлага дээрээс (11, 12) товчлуурыг дарахад сувгууд солигдож дэлгэцийн баруун дээд буланд сонгосон бусад суваг дээр ямар нэвтрүүлэг гарч байгааг харах цонх гарч ирнэ. Хэрвээ тухайн сувгийг үзэхийг хүсвэл (10) товчлуурыг дарна.


## 2. ТВ СУВГУУД



## 2.4. СУВАГ ҮЗЭХ







Үзэж байгаа нэвтрүүлэг дуусахаас тодорхой хугацааны өмнө дараагийн нэвтрүүлгийн талаарх товч танилцуулга бүхий сануулга дэлгэцийн баруун дээд буланд тогтмол гарна. Хэрвээ энэ сануулгыг огт гаргахгүй болгох эсвэл сануулга өгөх хугацааг өөрчлөх бол **Тохиргоо-ТВ тохиргоо-HD Вох-Сануулах** цэснээс тохируулах боломжтой.

Нэвтрүүлэг үзэж байхад дэлгэцийн доод хэсэгт тухайн сувгийн ерөнхий мэдээллүүд гарна. Үүнд: (Зүүнээс баруун тийш)



1. Сувгийн таних тэмдэг
2. Сувгийн дэс дугаар
3. Телевизийн цаг
4. Сувгийн нэр
5. Сувгийн төрөл

## 2. ТВ СУВГУУД

- б. Сувгийн товч мэдээлэл (Таних тэмдгүүд ногоон өнгөтэй байвал тухайн үйлдэл хийгдэх боломжтой эсвэл хийгдсэн болно.)
- a.  Нөхөж үзэж болно.
  - b.  Сануулах тохиргоо хийгдсэн.
  - c.  Түр зогсоож болно.
  - d.  Бичлэг хийж болно.
  - e.  Суваг түгжигдсэн.
  - f.  Дуу дүрсний өндөр чанартайгаар үзэж байна.

### 2.5. ТӨЛБӨРТЭЙ СУВАГ ҮЗЭХ/ТҮГЖИХ

Төлбөртэй суваг тавихад дэлгэцэн дээр “Сувгийг түгжсэн байна” гэсэн мэдээлэл бүхий цонх гарсан байна. Төлбөртэй сувгийг худалдан авахын тулд Универсал удирдлага дээрээс (20) товчлуурыг дарж суваг худалдан авах цонх руу шилжинэ. Үүний дараа нэвтрэх нууц үгийг оруулснаар тухайн сувгийг үзэх эрх нээгдэнэ.

### 2.6. НЭВТРҮҮЛЭГ ДАХИН ЭХЛҮҮЛЭХ, ТҮР ЗОГСООХ, НӨХӨЖ ҮЗЭХ, ГҮЙЛГЭХ

Зөвхөн нөхөж үзэх боломжтой сувгуудын нэвтрүүлгийг дахин эхлүүлэх, нөхөж үзэх боломжтой. Дахин эхлүүлэх, нөхөж үзэх боломжтой нэвтрүүлгүүдийг ТВ хөтөлбөр доторх улбар шар өнгөөр тодотгосон байна. Нэвтрүүлгийг дахин эхлүүлэхийн тулд Универсал удирдлага дээрээс (23) товчлуурыг дарахад эхнээсээ гарч эхэлнэ.

Нэвтрүүлгийг түр зогсоохын тулд Универсал удирдлага дээрээс (24) товчлуурыг дарна. Нэвтрүүлгийг түр зогсоосноос хойш 5 секундын дараа бичлэг хийж эхлэх бөгөөд ахин (24) товчлуур дарахад түр зогссон хэсгээс үргэлжилнэ. Үүнээс хойш шууд эфирээс хэр хоцрогдолтойгоор тухайн нэвтрүүлгийг үзэж байгааг дэлгэцийн баруун доод булангаас харах боломжтой. Хэрвээ шууд эфир үзэх бол (26) товчлуурыг дарна.

Нөхөж үзэж байгаа болон бичиж авсан нэвтрүүлгийг түр зогсоох бол (24) эсвэл (27) товчлуур, үргэлжлүүлэх бол (24) товчлуур, урагш хойш гүйлгэх бол (23, 25) товчлуур, шууд эфир үзэх бол (26) товчлуурыг дарна. Мөн (13, 14) товчлуурууд ашиглан урагш хойш гүйлгэх боломжтой.

## 2. ТВ СУВГУУД

Нэвтрүүлгийг нөхөж үзэх хоёр арга бий. Үүнд:

1. Сувгийн хөтөлбөрөөс: Универсал удирдлага дээрээс (13) товчлуурыг дарж тухайн суваг дээр өмнө гарсан нэвтрүүлгүүдийг үзэх ба нөхөж үзэхийг хүссэн нэвтрүүлэг дээрээ (11, 12) товчлуурын тусламжтайгаар очиж (10) товчлуурыг дарж нөхөж үзнэ.
2. ТВ хөтөлбөрөөс: ТВ хөтөлбөрүүдээс нөхөж үзэх нэвтрүүлэг дээрээ (13, 14) товчлуур ашиглан очиж (10) товчлуурыг дарна. Үүний дараа дэлгэцэн дээр гарах сонголтуудаас нөхөж үзэх сонголтыг сонгож хүссэн нэвтрүүлгээ нөхөж үзэж болно.

### 2.8. НЭВТРҮҮЛЭГ САНУУЛАХ

Сануулсан нэвтрүүлэг гарахаас 5 минутын өмнө өөр суваг дээр нэвтрүүлэг гарч байхад эсвэл видео сангаас видео контент үзэж байхад дэлгэцэн дээр сануулах мессеж гарна. Нэвтрүүлгийг сануулахын тулд тухайн нэвтрүүлгийн хөтөлбөр дээр очиж (нэвтрүүлгийн хөтөлбөр гаргах зааврыг ТВ хөтөлбөр хэсгээс уншина уу) (10) товчлуур дарна. Үүний дараа дэлгэцэн дээр гарах сонголтуудаас Сануулах сонголтыг сонгож сануулга өгөх хугацаа болон автоматаар суваг солигдох эсэхийг тохируулж ахин (10) товчлуур дарснаар сануулах тохиргоог идэвхжүүлнэ.

Автоматаар сануулга өгч, суваг солих бол Универсал удирдлага дээрээс (19) товчлуурыг дарна. (19) товчлуурыг дарахад дэлгэцэн дээр Суваг руу шилжих текст гарч ирнэ. Автоматаар суваг солихгүйгээр тохируулах бол (19) товчлуурыг ахин дарахад дэлгэцэн дээрх Суваг руу шилжих текст алга болно.

## 3. ВИДЕО САН (VOD)

---

### 3. ВИДЕО САН (VOD)

Дээрх цэсэнд IPTV үйлчилгээний видео санд байгаа бүх видео контентууд, тэдгээрийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, түрээслэх, найздаа бэлэглэх, санал болгох сонголтууд гэх мэт тохиргоог хийх боломжтой.

#### 3.1. ВИДЕО САНГ ХАРАХ

Видео сан цэс рүү ороход IPTV үйлчилгээнд орсон бүх төрлийн видео контент, шоу нэвтрүүлэг, жүжиг зэргийг ангилсан жагсаалт гарч ирнэ. Үүнээс та өөрийн хүссэн видео контентийг сонгон авч (10) товчлуурыг дарахад видео контентийн танилцуулга гарах ба (13,14) товчлуур ашиглан дэлгэрэнгүй мэдээлэл авах, түрээслэх, бэлэглэх, санал болгох, үзэх дуртай кино болгох боломжтой.

#### 3.2. ВИДЕО КОНТЕНТ ТҮРЭЭСЛЭХ

Видео сан цэснээс түрээслэхийг хүссэн видео контентоо сонгож (10) товчлуурыг дарахад тухайн видео контентийн дэлгэрэнгүй мэдээлэл гарч ирнэ. Үүний дараа Универсал удирдлагын (20) товчлуурыг дарах эсвэл (10) товчлуурыг дарахад гарах сонголтуудаас Түрээслэх сонголтыг сонгоно. Нэвтрэх нууц үгийг оруулж ахин (10) товчлуур дарснаар видео контентийг амжилттай түрээслэнэ. Ахин (20) товчлуурыг дарахад видео контентийг тоглуулж эхэлнэ.

#### 3.3. ВИДЕО КОНТЕНТИЙГ ТҮР ЗОГСООХ, ЗОГСООХ, ГҮЙЛГЭХ

Түрээсэлж авсан видео контентийг түр зогсоох бол (24) эсвэл (27) товчлуур, үргэлжлүүлэн үзэх бол (24) товчлуур, урагш хойш гүйлгэх бол (23, 25) товчлуур, бүр зогсоох бол (26) товчлуурыг дарна.

#### 3.4. ТЭМДЭГЛЭГЭЭ ХИЙХ

Түрээсэлсэн болон бичиж авсан видео контентод тэмдэглэгээ хийх боломжтой бөгөөд тэмдэглэгээ хийснээр тодорхой цаг минутыг тэмдэглэн авч тухайн хэсгээс нь эхлэн үзэх юм. Тэмдэглэхийг хүссэн цаг, минут дээрээ очиж Универсал удирдлага дээрээс (22) товчлуурыг дарна. Дэлгэцийн баруун дээд буланд тэмдэглэгээ хийсэн минутын мэдээлэл бүхий цонх гарч ирэх ба таны хамгийн сүүлд хийсэн тэмдэглэгээ жагсаалтын хамгийн сүүлд бичигдэнэ.

### 3. ВИДЕО САН (VOD)




Харин Универсал удирдлага дээрээс (20) товчлуурыг дарахад дэлгэцийн баруун дээд буланд өмнө нь хийгдсэн бүх тэмдэглэгээнүүдийн жагсаалт гарах ба үзэхийг хүссэн хэсгээ жагсаалтаас сонгож (10) товчлуур дарснаар тухайн тэмдэглэсэн хэсгээс ахин видео контентийг тоглуулна.

#### 3.5. ВИДЕО КОНТЕНТИЙГ БЭЛЭГЛЭХ, САНАЛ БОЛГОХ


Видео сан цэснээс видео контент бэлэглэхийн тулд Видео сан цэс рүү орж сонгосон видео контентийн дэлгэрэнгүй мэдээлэл бүхий хэсэгт очоод (10) товчлуур дарахад гарах сонголтуудаас Бэлэглэх сонголтыг сонгоно. Үүний дараа видео контент бэлэглэх хэрэглэгчийг жагсаалтаас сонгож нэвтрэх нууц үгийг оруулснаар видео контентийг бэлэглэнэ.



### 3. ВИДЕО САН (VOD)




Видео контент бэлэглэсэн хэрэглэгчийн дэлгэцийн баруун талд видео контент бэлэглэсэн тухай сануулах мессеж гарч ирэх ба тухайн видео контент нь Видео сан- Миний түрээсэлсэн цэсэнд хадгалагдана.



Видео контент санал болгохын тулд Видео сан цэс рүү орж сонгосон видео контентийн дэлгэрэнгүй мэдээлэл бүхий хэсэгт очоод (10) товчлуур дарна. Үүний дараа дэлгэцэнд гарах

### 3. ВИДЕО САН (VOD)

сонголтуудаас Найздаа санал болгох сонголтыг сонгоход таны IPTV-ээр холбогдсон найзуудын жагсаалт гарна. Санал болгохыг хүссэн хэрэглэгч дээр очиж (10) товчлуур дарсны дараа нэвтрэх нууц үг оруулж баталгаажуулснаар найздаа санал болгоно.



#### 3.6. ТРЕЙЛЭР ҮЗЭХ, ҮЗЭХ ДУРТАЙ КИНО БОЛГОХ

Трейлэр үзэх болон үзэх дуртай видео контентийн жагсаалтанд нэмэхийн тулд Видео сан цэс рүү орж сонгосон видео контентийн дэлгэрэнгүй мэдээлэл бүхий хэсэгт очиж (10) товчлуур дарна. Дэлгэцэн дээр гарч ирэх сонголтуудаас Трейлэр үзэх эсвэл Үзэх дуртай кино сонголтыг сонгоно. Хэрвээ Трейлэр үзэж байхдаа түр зогсоох бол (24) эсвэл (27) товчлуур, үргэлжлүүлэх бол (24) товчлуур, урагш хойш гүйлгэх бол (23, 25) товчлуур, бүр зогсоох бол (26) товчлуурыг дарна.

## 4. МИНИЙ КОНТЕНТ

---

### 4. МИНИЙ КОНТЕНТ

#### 4.1. БИЧЛЭГ ХИЙХ, ҮЗЭХ, ТӨЛӨВЛӨХ

Өөрийн хүссэн нэвтрүүлгийг бичихийн тулд тухайн нэвтрүүлгийн хөтөлбөр дээр очиж (нэвтрүүлгийн хөтөлбөр гаргах зааврыг ТВ хөтөлбөр хэсгээс уншина уу) (10) товчлуурыг дарна. Үүний дараа дэлгэцэн дээр гарах сонголтуудаас **Бичлэг хийх** сонголтыг сонгож ахин (10) товчлуурыг дарж бичлэг хийж эхэлнэ. Хэрвээ бичихийг хүссэн нэвтрүүлэг цацагдах хугацаа болоогүй байвал тухайн нэвтрүүлэг **Миний контент- Төлөвлөсөн бичлэг** цэсэнд автоматаар нэмэгдэнэ.

Бичиж авсан нэвтрүүлгүүд нь **Миний контент- Миний бичлэг** цэсэнд хадгалагдана. Та нийт 4320 минут хүртэлх хэмжээний бичлэг хадгалах эрхтэй бөгөөд үүнээс илүү минутын бичлэг хадгалах боломжгүй болохыг анхаарна уу.

#### 4.2. FLICKR ГЭРЭЛ ЗУРГУУД

Дээрх цэсэнд та өөрийн Flickr дээрх зургуудыг IPTV-д холбож өндөр чанартайгаар үзэх боломжтой. Үүний тулд эхлээд **Тохиргоо- Бусад тохиргоо** цэс доторх **Flickr** бүртгэлийг идэвхжүүлсэн байх шаардлагатай.

#### 4.3. САНАЛ БОЛГОСОН ВИДЕО КОНТЕНТ

Дээрх цэсэнд танд санал болгосон видео контентуудын жагсаалт байна. Санал болгосон видео контентийг үзэхийн тулд Универсал удирдлага дээрээс (11,12 эсвэл 13,14) товлуур ашиглан видео контент дээрээ очиж (10) товчлуур дарна. Хэрвээ та тухайн видео контентийг түрээсэлж авсан бол **Тоглуулах**, түрээсэлж аваагүй бол **Түрээслэх** сонголтыг сонгож видео контентийг үзэж эхэлнэ.

## 5. ТВ АППЛИКЕЙШН

### 5. ТВ АППЛИКЕЙШН

Дээрх цэснээс IPTV-ээр холбогдох боломжтой бүх төрлийн өргөн хэрэглээний аппликейшнийг ашиглах боломжтой. Удирдлага дээрх (7) товчлуурыг дарж (13, 14) товчлуурын тусламжтай ТВ App цэс рүү шилжинэ.

#### 5.1. БҮХ АППЛИКЕЙШНИЙН ЖАГСААЛТ ХАРАХ

Дээрх цэсэнд IPTV дээр холбогдох боломжтой бүх аппликейшнийн жагсаалт гарах бөгөөд аппликейшн тус бүрийн дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцахын тулд Универсал удирдлага дээрээс (11, 12) товч ашиглан очиж (10) товчлуурыг дарахад гарах сонголтуудаас **Тайлбар** сонголтыг сонгоно. Хэрвээ тухайн аппликейшнийг худалдан авах бол **Худалдан авах** сонголтыг сонгож нэвтрэх нууц үгийг оруулна. Худалдан авсан аппликейшнийг дахин худалдан авах шаардлагагүй ба ажиллуулахыг хүсвэл аппликейшн дээрээ (11, 12) товчлуур ашиглан очиж (10) товчлуур дээр дарна. Үүний дараа **Идэвхжүүлэх** сонголтыг сонгоно.

#### 5.2. МИНИЙ АППЛИКЕЙШНИЙН ЖАГСААЛТ ХАРАХ

Миний Аппликейшн цэсэнд худалдан авсан эсвэл үнэгүй цэснээс татаж авсан таны бүх аппликейшнийн жагсаалт байна. Аппликейшнийн дэлгэрэнгүй мэдээлэл авах болон ажиллуулахыг хүсвэл сонгосон аппликейшн дээрээ (11, 12) товчлуур ашиглан очиж (10) товчлуур дээр дарна. Үүний дараа дэлгэцэн дээр гарах сонголтуудаас өөрт хэрэгтэйг сонгоно

#### 5.3. UNIVISIONSTORE ЖАГСААЛТ ХАРАХ

UnivisionStore цэсэнд Юнивишнээс танд санал болгож буй бүх төрлийн аппликейшнийн жагсаалт байна. Хэрвээ UnivisionStore-оос аппликейшн худалдан авах бол **Худалдан авах** сонголтыг сонгож нэвтрэх нууц үгийг оруулна. Худалдан авсан аппликейшнийг дахин худалдан авах шаардлагагүй ба ажиллуулахыг хүсвэл аппликейшн дээрээ (11, 12) товчлуур ашиглан очиж (10) товчлуур дээр дарна. Үүний дараа **Идэвхжүүлэх** сонголтыг сонгоно.

#### 5.4. ҮНЭГҮЙ АППЛИКЕЙШНИЙН ЖАГСААЛТ ХАРАХ

Үнэгүй аппликейшн цэсэнд зөвхөн төлбөргүй аппликейшнүүд байна. Аппликейшнийг татаж авах, ажиллуулах, дэлгэрэнгүй мэдээлэл авахын хүсвэл (11, 12) товчлуур ашиглан очиж (10) товчлуур дээр дарна. Үүний дараа дэлгэцэн дээр гарах сонголтуудаас өөрт хэрэгтэйг сонгоно.

## 5. ТВ АППЛИКЕЙШН

### 5.5. ӨРГӨН ХЭРЭГЛЭГДДЭГ АППЛИКЕЙШНҮҮДИЙГ АШИГЛАХ

Та худалдан авсан аппликейшнүүдээ Өргөн хэрэглэгддэг аппликейшн цэст нэмж болно. **ТВ Аппликейшн** цэсэн дэх дурын аппликейшн дээр (11, 12) товч ашиглан очиж (10) товчлуурыг дарахад гарах сонголтуудаас **Цэс дээр нэмэх** сонголтыг сонгоход тухайн аппликейшн өргөн хэрэглэгддэг аппликейшнийн жагсаалтад орно. Хэрвээ дээрх жагсаалтаас хасахыг хүсвэл сонгосон аппликейшн дээр (11, 12) товч ашиглан очиж (10) дарахад гарах сонголтуудаас **Цэснээс устгах** сонголтыг сонгоно.

Өргөн хэрэглэгддэг аппликейшн жагсаалтыг харахын тулд нэвтрүүлэг үзэж байхдаа (10) товчлуурыг хоёр дарахад дэлгэцийн зүүн доод буланд байрлах (сүвгийн тэмдэг, сүвгийн нэр, сүвгийн төрөл) мэдээллийн дэвсгэр өнгө нь саарал болсон байна. (Зураг)



Энэ үед Универсал удирдлага дээрээс (14) товч дарахад өргөн хэрэглэгддэг аппликейшнийн жагсаалт гарч ирнэ. Удирдлага дээрх (13,14) товчлуурыг ашиглан аппликейшнаа сонгож (10) товчлуурыг дарж ажиллуулна.

Facebook, Twitter, Flickr гэх мэт хувь хүний ID-г хийж ашигладаг аппликейшнүүдийг ашиглахын өмнө **Тохиргоо- Бусад тохиргоо** цэс дотор аппликейшн бүрт хамаарах ID-г оруулж өгнө. Энэ талаарх дэлгэрэнгүй зааврыг **Тохиргоо- Бусад тохиргоо** хэсгээс уншина уу.

## 6. ТОХИРГОО

### 6. ТОХИРГОО

IPTV-г ашиглахад шаардлагатай үндсэн тохиргоонуудыг дээрх цэсэнд хийнэ. Хэрэглэгчийн үндсэн тохиргоо, ТВ тохиргоо, Админы хяналт зэрэг шаардлагатай тохиргоонуудыг дээрх цэснээс хийж болно.

#### 6.1. ҮНДСЭН ТОХИРГОО ХИЙХ

Дээрх цэс нь IPTV-ийн үндсэн тохиргоо хийх цэс бөгөөд дараах тохиргоонуудыг хийх боломжтой. Үүнд:

1. **Нууц үг солих:** Энэ сонголт нь IPTV-д анх нэвтэрч ороход ашиглагддаг одоогийн нэвтрэх нууц үгийг солих тохиргоо юм. Нэвтрэх нууц үгийг солихын тулд баталгаажуулах зорилгоор одоогийн нэвтрэх нууц үгийг дахин оруулна. Үүний дараа

• **Шинэ нууц үг**

• **Шинэ нууц үгээ давтах**

сонголтууд гарч ирнэ. Универсал удирдлага дээрээс (11, 12) товчлуураар **Шинэ нууц үг** сонголт дээр очиж (3) товчлуур ашиглан шинэ нууц үгийг оруулна (10 товчлуур дарахгүй болохыг анхаарна уу). Үүний дараа (11) товчлуураар **Шинэ нууц үгээ давтах** сонголт дээр очиж шинэ нэвтрэх нууц үгийг дахин оруулна. Ингээд (17) товчлуурыг дарснаар нэвтрэх нууц үг шинэчлэгдэнэ.

2. **Шууд нэвтрэх:** Энэ тохиргоо нь та IPTV-д нэвтрэхдээ нууц үг оруулдаггүй болгох тохиргоо юм. Шууд нэвтрэх тохиргоог хийхийн тулд **Тохиргоо-Үндсэн тохиргоо-Шууд нэвтрэх** цэс рүү очиж Админ нууц үгийг оруулна. Үүний дараа Шууд нэвтрэлт сонголтын төлвийг чагтласан байгааг Универсал удирдлага дээрээс (x) болгож өөрчлөх ба (17) товчлуур дарж тохиргоог баталгаажуулна.

3. **Хэл солих:** Энэ тохиргоо нь IPTV-ийн хэлийг солих тохиргоо бөгөөд хэл сонгосон тохиолдолд төхөөрөмж автоматаар унтарч асахыг анхаараарай.

4. **Эрх нэмэх/хасах:** Хэрвээ та Админ эрхтэй хэрэглэгч бол IPTV-г ашиглах гэр бүлийн гишүүдийн эрхийг нэмж, хасах боломжтой. **Тохиргоо-Үндсэн тохиргоо-Эрх нэмэх/хасах** цэс рүү ороход өмнө үүссэн хэрэглэгчдийн нэвтрэх нэр болон **Шинэ хэрэглэгч нэмэх** гэсэн сонголт бүхий жагсаалт гарч ирнэ. Шинэ хэрэглэгч нэмэх сонголтыг сонгоход хэрэглэгчийн нэвтрэх нэр оруулах цонх гарч ирэх ба нэвтрэх нэрийг бичиж Универсал удирдлага дээрээс (17) товчлуур дарснаар тухайн шинээр үүссэн хэрэглэгчийн 10 оронтой нууц дугаар гарч ирнэ.

Хэрвээ хэрэглэгчийн эрх хасах бол хасах хэрэглэгч дээрээ удирдлагын (11, 12) товчлуур ашиглан очиж (10) товчлуур дарж хэрэглэгчийг устгах сонголтыг сонгоно.

5. **Хэрэглэгчийг солих:** Хэрвээ өөр хэрэглэгчийн эрхээр орох эсвэл гарах бол дээрх тохиргоог хийнэ. Энэ тохиргоог хийхэд заавал IPTV-ээ унтраах шаардлагагүй.

## 6. ТОХИРГОО

---

### 6.2. ТВ ТОХИРГОО ХИЙХ

Дээрх цэсэнд ТВ нэвтрүүлгийг сануулах, үзэх дуртай сувгийн дарааллыг өөрчлөх, дэлгэцийн хэмжээг тохируулах гэх мэт суваг, нэвтрүүлэгтэй холбоотой тохиргоог хийнэ. ТВ тохиргоонд дараах тохиргоонууд багтана.

1. **HD Vox:** Энэ нь суваг үзэж байхад гарах нэмэлт сануулга, аудио болон хадмал орчуулга, дэлгэцийн хэмжээг тохируулах цэс юм.

1.1. Нэвтрүүлэг дуусахаас өмнө дараагийн нэвтрүүлгийн талаарх товч мэдээллийг дэлгэцийн баруун дээд буланд хэдэн минутын өмнө гарахыг тохируулна. Минутын тохиргоог хийхийн тулд Тохиргоо-ТВ тохиргоо-HD Vox-Сануулах цэс рүү орж минутыг Универсал удирдлага дээрээс (11,12) товчлуур ашиглан тохируулна.

1.2. Зарим сувгууд Dual Language буюу тухайн оронд тусгайлан зориулсан дуу, хадмал орчуулгатай байдаг. Хэрвээ нэвтрүүлэг үзэж байхдаа дуу болон хадмал орчуулгыг харах бол Тохиргоо-ТВ тохиргоо-HD Vox-Дуу эсвэл Хадмал орчуулга цэс рүү орж төлвийг нь (10) товчлуурын тусламжтай Идэвхжсэн төлөвт шилжүүлнэ.

1.3. Дэлгэцийн хэмжээ цэсэнд танай гэрт ашиглагдаж байгаа ТВ-ийн дэлгэцийн хэмжээг тааруулах тохиргоо хийнэ.

2. **Үзэх дуртай сувгууд:** IPTV-ээр гарч буй бүх сувгуудаас өөрийн үзэх дуртай сувгуудыг сонгож сувгийн төрөл үүсгэх тохиргоо юм. Энэ цэсэнд хийгдсэн тохиргоо нь Сувгийн төрөл цэсний Үзэх дуртай сувгууд төрөлд багтана. Үзэх дуртай сувгуудыг сонгохын тулд Тохиргоо-ТВ тохиргоо-Үзэх дуртай сувгууд цэс рүү орж (11, 12) товчлуурын тусламжтай суваг дээрээ очоод (10) товчлуурыг дарахад сонгосон сувгийн ард чагт үүсч Үзэх дуртай суваг-т орсон байна.

### 6.3. ХУВИЙН ТОХИРГОО ХИЙХ

Энэ цэсэнд хэрэглэгч өөрийн хувийн мэдээллийг тохируулах боломжтой. Тохиргоо-Хувийн тохиргоо цэс рүү орж өөрийн чат дээрх хувийн мэдээллүүдийг оруулна.

Мөн санал болгож буй зүйлс цэсэнд Юнивишнээс эсвэл IPTV-ээр холбогдсон найзуудын тань санал болгож буй видео контент, нэвтрүүлгүүдийн мэдээллийг авах эсэхийг тохируулна. Хэрвээ дээрх мэдээллүүдийг авахыг хүсвэл сонголтуудыг Идэвхжсэн төлөвт шилжүүлнэ.

## 6. ТОХИРГОО

### 6.4. АДМИН ХЯНАЛТ ХИЙХ

Хэрвээ та Админ эрхтэй хэрэглэгч бол бусад гэр бүлийн гишүүдийн үзэж болох суваг, видео контентийг тохируулах болон гишүүд тус бүрт насны хязгаарлалт хийх боломжтой. Админ хяналт цэсэнд дараах тохиргоонууд багтана. Үүнд:

1. **Админ нууц үг өөрчлөх:** Админ нууц үгийг энэ цэсэнд өөрчилнө. Тохиргоо-Админ хяналт цэс рүү орж (3) товчлуур ашиглан Админ нууц үгээ оруулах ба (17) товчлуур дарж тохиргоог баталгаажуулна.

2. **Сувгийн жагсаалт:** Гэр бүлийн гишүүд тус бүр ямар суваг үзэж болох, болохгүйг тохируулах тохиргоог энэ цэсэнд хийнэ. Тохиргоо-Админ хяналт цэс рүү орж тохиргоо хийхийг хүссэн хэрэглэгчийг жагсаалтаас сонгоход бүх сувгийн жагсаалт бүхий дэлгэц гарч ирнэ. Универсал удирдлага дээрээс (11, 12) товчлуур ашиглан сувгууд дээр очиж (10) товчлуурыг дарахад тухайн сувгийн өмнө анхааруулах тэмдэг гарч ирнэ. Энэ нь сувгийг тухайн хэрэглэгч үзэх эрхгүй, түгжигдэнэ гэсэн үг юм. Ингээд тодорхой сувгуудын өмнө анхааруулах тэмдэг тависны дараа Универсал удирдлага дээрээс (17) товчлуур дарж тохиргоог баталгаажуулна.

3. **Эцэг эхийн хяналт:** Энэ цэсэнд гэр бүлийн гишүүдийн үзэх видео контентийг хянах боломжтой. Тохиргоо-Админ хяналт-Эцэг эхийн хяналт цэс рүү орж хяналт үүсгэхийг хүссэн хэрэглэгчийн нэвтрэх нэрийг сонгоход Эцэг эхийн хяналтын нас текст гарч ирнэ. Энэ хэсэгт тухайн хэрэглэгч хэдэн настайг оруулж өгч хадгална. Жишээ: Хэрвээ тухайн хэрэглэгч 20 настай гэж оруулбал зөвхөн 20 хүртэлх насны хүмүүс үзэхийг зөвшөөрсөн видео контент, нэвтрүүлэг үзэх эрхтэй болно.

### 6.5. ТӨХӨӨРӨМЖИЙН ТОХИРГОО ХИЙХ

Энэ цэсэнд "UNIVISION" гар утасны аппликейшн ашиглаж байгаа болон Smart Vox зэрэг IPTV-д холбогдсон бүх төхөөрөмжийн дэлгэрэнгүй мэдээлэл бүхий жагсаалт харагдах ба төхөөрөмжүүдийг хянах, салгах тохиргоо хийх боломжтой. Та зөвхөн тодорхой тооны төхөөрөмжүүдийг IPTV-д холбох эрхтэй байна. Хэрвээ нийт холбогдсон төхөөрөмжүүдийн тоо нь гүйцсэн боловч та ахин нэг төхөөрөмж холбох шаардлагатай бол хуучин холбосон төхөөрөмжүүдээсээ аль нэгийг нь салгах шаардлагатай. Хэрвээ төхөөрөмж салгах бол тухайн төхөөрөмжийг сонгон гарах дэлгэцээс Төхөөрөмж салгах сонголтыг сонгоно.



## 6. ТОХИРГОО

---

### 6.6. СИСТЕМИЙН ТОХИРГОО ХИЙХ

Дээрх цэсэнд HD Vox төхөөрөмжийн мэдээлэлтэй танилцах, төхөөрөмжийг дахин эхлүүлэх зэрэг тохиргоог хийж болно. Тохиргоо-Системийн тохиргоо-HD Vox мэдээлэл цэсэнд төхөөрөмжийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэлтэй танилцах боломжтой. Тохиргоо-Системийн тохиргоо-HD Vox унтрааж, асаах цэсэнд төхөөрөмжийг ахин эхлүүлэх тохиргоог хийх ба энэ тохиргоог хийхэд хэрэглэгчийн төлөв өөрчлөгдөхийг анхаарна уу.

### 6.7. БУСАД ТОХИРГОО ХИЙХ

Дээрх цэсэнд өөрийн эрхийн 10 оронтой PIN нууц үг болон ТВ аппликейшнүүдтэй холбоотой нэмэлт тохиргоог хийх боломжтой. Энэ цэсийг сонгохын тулд нэвтрэх нууц үгийг оруулна. Дараах тохиргоонуудаас бүрдэнэ. Үүнд:

1. **Нэвтрэх нууц үг:** Univision Mongolia аппликейшнд нэвтрэх 10 оронтой нууц үгийг энэ цэснээс харах боломжтой. Үүнд нэвтрэхийн тулд IPTV-д нэвтрэх нууц үгийг оруулна.

2. **Facebook, Twitter, Flickr бүртгэл:** Хувь хүний мэдээлэл буюу ID, нууц үг шаарддаг аппликейшнүүдийг ажиллуулахын тулд дээрх бүртгэлийг зайлшгүй хийх шаардлагатай. Хэрвээ энэ бүртгэлийг хийхгүй бол ТВ App цэснээс худалдаж авсан тухайн аппликейшн нь бүрэн ажиллахгүй болохыг анхаарна уу. Аппликейшний бүртгэл хийхийн тулд Тохиргоо-Бусад тохиргоо цэсэнд байрлах Facebook бүртгэл, Twitter бүртгэл, Flickr бүртгэл сонголтыг сонгож дээрх аппликейшнд бүртгүүлсэн өөрийн цахим шуудангийн хаягийг оруулж (17) товчлуур дарснаар тохиргоог баталгаажуулна. Үүний хариуд таны цахим шуудангийн хаягт баталгаажуулах захиа ирэх ба түүнийг дарж баталгаажуулалт хийж дахин Тохиргоо- Бусад тохиргоо цэсийг уншуулж ТВ аппликейшнийг ашиглах боломжтой болно.


3. **RSS Feed:** Энэ цэсэнд өдөр тутмын онцлох мэдээллүүдийг ямар эх сурвалжаас авахыг тохируулах боломжтой ба ТВ Аппликейшн цэсний RSS Feed аппликейшн дээр гарах мэдээллүүдийг энэ хэсэгт тохируулна. Эх сурвалж нэмэхийн тулд тухайн эх сурвалж дээр Универсал удирдлага дээрээс (11, 12) товчлуур ашиглан очиж (10) дарахад эх сурвалжийн ард чагт үүссэн байна. Хэрвээ эх сурвалжийг хасах бол ардаа чагттай эх сурвалж дээр очиж (10) товчлуурыг дарах ба энэ үед тухайн эх сурвалжийн ард байсан чагт алга болно. Ингээд (10) дарж тохиргоог баталгаажуулна.

4. **Цаг агаар:** ТВ Аппликейшн цэсний Цаг агаар аппликейшнийг энэ цэсэнд удирдаж болно. Шинээр хотын цаг агаар нэмэх бол нэмэхийг хүссэн хот дээр Универсал удирдлагын (11,12) товчлуур ашиглан очиж (10) дарахад хотын ард чагт үүссэн байна. Хэрвээ хот хасах бол чагттай хот дээр очиж (10) дарах ба энэ үед тухайн хотын ард байсан чагт алга болно. Ингээд (10) товчлуурыг дахин дарж тохиргоог баталгаажуулна.

## 7. ПРОМО

## 7. ПРОМО

Промо цэс нь IPTV-ийн бүтээгдэхүүн үйлчилгээ, урамшууллын талаар танд хэрэгтэй мэдээллийг цаг алдалгүй хүргэх цэс юм. Энэ цэсэнд GG оноогоор хэрхэн видео контент түрээслэх заавар, Smart VOD, Sport Box гэх мэт бүх төрлийн үйлчилгээний талаарх мэдээллүүдтэй танилцах боломжтой.




## 8. ТӨЛБӨР

### 8. ТӨЛБӨР

Энэ цэсэнд IPTV-ийн видео сан болон бусад үндсэн, нэмэлт үйлчилгээнд зарцуулсан төлбөрийн мэдээлэлтэй танилцах боломжтой.

#### 8.1. ТӨЛБӨРИЙН ДҮНГ ХАРАХ

Дээрх цэсийг сонгоход төлбөр гарсан хугацаа, авсан үйлчилгээний товч хураангуй тайлан, төлбөрийн нийт дүн бүхий мэдээлэл гарч ирнэ. Хэрвээ төлбөр хийх хугацааг солих бол удирдлагын (20) товчлуурыг дарна. Үүний дараа (11, 12) товчлуур ашиглан Төлбөрийн дэлгэрэнгүй сонголтыг сонгож (20) товчлуурыг дарснаар сонгосон хугацаанд гарсан төлбөрийн товч тайлантай танилцах боломжтой.



The screenshot shows a user interface for viewing payment details. At the top, there are several icons: a gear, a shopping bag, a shopping cart, a question mark, and a group of people. Below these icons, the text "ТӨЛБӨР" (Payment) is displayed in green, followed by "• төлбөрийн дүн" (Payment summary). The date "2014.08.25" and the time "16:21" are shown in the top right corner. The main content area contains a table with the following data:

Төлбөр тооцоо хийх хугацаа: 8-р сар 2014	
Видео сан	36,800 MNT
Төлбөрийн дүн	36,800 MNT

At the bottom of the screen, there are navigation buttons: "Буцах" (Back) with a left arrow, "Төлбөр хийх хугацааг сон..." (Select payment period...) with a green dot, and "Шилжих" (Next) with a right arrow.

#### 8.2. ВИДЕО САНГИЙН ТӨЛБӨР ХАРАХ

Энэ цэсийг сонгоход тухайн сард видео сангаас ямар видео контент түрээсэлж авсан тухай мэдээллэх товч тайлан бүхий жагсаалт гарч ирнэ.

## 8. ТӨЛБӨР

ТӨЛБӨР • видео сан 2014.08.25 16:22

Төлбөр тооцоо хийх хугацаа: 8-р сар 2014

Despicable Me 2 Монгол Хэлээр	2014.08.25	4,900 MNT
Oblivion Монгол Хэлээр	2014.08.25	4,900 MNT
42 English	2014.08.25	4,500 MNT
300 English	2014.08.25	1,500 MNT
10,000 BC English	2014.08.25	1,500 MNT
102 Dalmatians English	2014.08.25	1,500 MNT
<b>Төлбөрийн дүн</b>		<b>36,800 MNT</b>

Буцах Төлбөр хийх хугацааг сон... Шилжих

## 8.3. СУУРЬ ХУРААМЖИЙН ТӨЛБӨР ХАРАХ

Дээрх цэс рүү ороход тухайн сард худалдаж авсан төлбөртэй сувгуудын мэдээлэл, товч тайлан бүхий жагсаалт гарч ирнэ.

ТӨЛБӨР • суурь хураамж 2014.08.25 16:23

Төлбөр тооцоо хийх хугацаа: 8-р сар 2014


Төлбөр гараагүй байна

Буцах Төлбөр хийх хугацааг сон... Шилжих

## 9. ТУСЛАМЖ

### 9. ТУСЛАМЖ


Тусламж цэсэнд IPTV ашиглахад тулгардаг түгээмэл асуудал, тэдгээрийн товч заавартай танилцах боломжтой



## 10. НАЙЗУУД

## 10. НАЙЗУУД

IPTV дотроо найз нөхдийн хүрээлэл бий болгож харилцах боломжтой ба Найзууд цэсэнд өөрийн хувийн мэдээлэл нэмэх, хоорондоо найзууд болох, найзын хүсэлт илгээх, найзын хүсэлт хүлээн авах цаашлаад хоорондоо чатлах боломжтой.

**10.1. ХУВИЙН МЭДЭЭЛЭЛ ХАРАХ**

IPTV-ийн найзуудад тань харагдах хувийн мэдээллийг энд оруулна. Хэрвээ хувийн мэдээллээ солих бол энэ цэсэнд ахин очиж хувийн мэдээлэлдээ засвар хийх боломжтой.

**10.2. НАЙЗУУДЫН МЭДЭЭЛЭЛ ХАРАХ**

IPTV-ийн бүх найзуудын хувийн мэдээллүүдийг энэ хэсэгт харж болно.

**10.3. НАЙЗЫН ХҮСЭЛТ ХАРАХ**

Дээрх цэсэнд тантай IPTV-ээр найзууд болох хүсэлт явуулсан хэрэглэгчдийн жагсаалттай танилцах боломжтой. Найзын хүсэлтийг зөвшөөрөх эсвэл татгалзахын тулд (11,12) товчлуур ашиглан очиж (10) товчлуур дарна. Үүний дараа дэлгэцэн дээр гарч ирэх сонголтоос хүссэн сонголтоо сонгож найзын хүсэлтийг зөвшөөрөх эсвэл татгалзана.

**10.4. НАЙЗЫН ХҮСЭЛТ ИЛГЭЭХ**


Та бусад IPTV ашигладаг найзууд руугаа хүсэлт илгээхийн тулд тухайн хэрэглэгчийн чатын нэр эсвэл IPTV-д бүртгэлтэй утасны дугаарыг нь мэдэх шардлагатай. Найзын хүсэлт илгээх

## 10. НАЙЗУУД

хэрэглэгчийнхээ чатын нэр эсвэл утасны дугаарыг оруулж (10) дарснаар хайлт хийх дэлгэц гарч ирнэ. Гарч ирсэн үр дүнгээс найзаа сонгож хүсэлтийг илгээнэ. Хүсэлт илгээсэн хэрэглэгч таны хүсэлтийг хүлээн авсан бол тухайн хэрэглэгч автоматаар таны Найзуудын мэдээлэл цэсэнд орно.

### 10.5. НАЙЗУУД ХООРОНДОО ЧАТЛАХ, ВИДЕО КОНТЕНТ БЭЛЭГЛЭХ, САНАЛ БОЛГОХ

ТВ суваг үзэж байхдаа найзууд хоорондоо чаталж болно. Үүний тулд суваг үзэж байхдаа удирдлагын (19) товчлуурыг дарахад дэлгэцийн баруун доод буланд чатлах цонх гарч ирнэ. Удирдлагын (20) товчлуурыг дарж чатлах найзаа нэмж (3) товчлуур дарж чатлаж эхэлнэ.



Найздаа видео контент бэлэглэх бол Видео сан цэснээс бэлэглэхийг хүссэн видео контентоо сонгоод (10) товчлуур дарахад гарах сонголтуудаас Бэлэглэх сонголтыг сонгоно. Үүний дараа Бэлэг илгээх хэрэглэгчийг жагсаалтаас сонгож Бэлэг худалдан авах цэсэнд нэвтрэх нууц үгийг илгээснээр видео контентийг амжилттай бэлэглэнэ. Видео контент бэлэглэж байгаа тохиолдолд тухайн видео контентийн түрээсийн төлбөрийг бэлэг илгээгч буюу та төлөх болохыг анхаарна уу.

Харин видео контент, нэвтрүүлэг санал болгох бол видео контентийн дэлгэрэнгүй мэдээлэл гарах цэс рүү орж (10) товчлуурыг дарахад гарах сонголтуудаас Найздаа санал болгох сонголтыг сонгоно. Үүний дараа жагсаалтаас хэрэглэгчийн чатын нэрийг сонгосноор тухайн видео контент, нэвтрүүлгийг санал болгоно. Видео контент санал болгож байгаа тохиолдолд санал болгож байгаа хэрэглэгч ямар нэг төлбөр төлөхгүй бөгөөд санал болгож буй контентийг үзэх сонголт хийсэн хэрэглэгч түрээсийн төлбөрийг төлнө.

## 11. ХАЙЛТ

### 11. ХАЙЛТ

Энэхүү цэсэнд IPTV-д орсон бүх видео контент, нэвтрүүлгүүдийг ангилж хайх боломжтой. Хайх сонголтонд хайх үгээ бичих ба бичихийн тулд (3) товчлуур дээр шууд дарахад хайх үг бичих текст гарч ирнэ. Үүний дараа удирдлагын (11, 12) товчлуур ашиглан Ангиллаар эсвэл Шүүлтүүрээр хайлт хийхийг сонгоно. Дээрх сонголтуудын аль нэгийг нь сонгосны дараа (13,14) товчлуур ашиглан дахин ангилж хайна. Ингээд бүх хайлтын тохиргоог хийсний дараа Универсал удирдлага дээрээс (22) товчлуурыг дарж хайлт хийнэ. Хэрвээ дахин хайлт хийх бол удирдлагын (22) товчлуурыг дарахад хангалттай.




## 12. “UNIVISION MONGOLIA” АППЛИКЕЙШН

### 12. “UNIVISION MONGOLIA” АППЛИКЕЙШН


“Univision Mongolia” гар утасны аппликейшн нь гар утсаараа IPTV-г ашиглах, видео сангаас видео контент үзэх боломжтой Юнивишнээс гаргаж буй аппликейшн юм. Та Андройд үйлдлийн системтэй гар утастай бол Playstore-оос Univision Mongolia түлхүүр үгээр хайж татаж аваарай. Univision Mongolia аппликейшн нь зөвхөн интернэтийн орчинд ажиллах бөгөөд аппликейшн гацсан эсвэл ажиллахгүй байвал интернэтийн холболт байгаа эсэхийг шалгахыг зөвлөж байна.

Аппликейшнд нэвтрэхийн тулд таны 10 оронтой нэвтрэх нууц үг шаардлагатай болно. Аппликейшнд нэвтрэх нууц үгийг хийсний дараа аппликейшний нүүр хуудсан дээр Тохиргоо, Видео сан, Миний контент, ТВ сувгууд цэс гарч ирнэ. Мөн дээрх цэсийн доор Stand Alone Mode буюу зөвхөн гар утсаараа үзэх, эсвэл TV Mode буюу IPTV-тэй холбож үзэх гэсэн үндсэн хоёр сонголттой байна. Нүүр хуудасны хамгийн доор гар утсаа удирдлага болгох товч болон тусламж авах товчлуур байна.



#### 12.1. ТВ СУВГУУД ҮЗЭХ


ТВ сувгууд цэс рүү орсноор та хүссэн сувгаа гар утсаараа үзэх боломжтой. Үзэхийг хүссэн суваг дээрээ дарахад тухайн сонгосон суваг дээр яг одоо явж байгаа нэвтрүүлэг шууд тоглогдож эхэлнэ.



## 12. “UNIVISION MONGOLIA” АППЛИКЕЙШН

### 12.2. ВИДЕО КОНТЕНТ ҮЗЭХ

Та хүссэн видео контентоо гар утсан дээрээ түрээслэн авч үзэх боломжтой. Үүний тулд Видео сан цэс рүү орж түрээслэх видео контентийг сонгоно. Аппликейшнд нэвтрэх нууц үгийг оруулж видео контентийг үзэж эхэлнэ.



### 12.3. ТОХИРГОО ХИЙХ

Тохиргоо цэс нь IPTV-ийн тохиргоо цэстэй ижил бөгөөд шаардлагатай тохиргоонуудын зааврыг IPTV-ийн тохиргоо цэснээс дэлгэрэнгүй уншина уу.

